



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Зөвлөгөөн зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.15, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 25 дугаар зүйлийн 25.4.2, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.9.1 д, е, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цус сэлбэлт судлалын салбарын сувилагчдын II зөвлөгөөн”-ийг 2025 оны 09 дүгээр сарын 25–26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2. Зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар, төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Зөвлөгөөнийг удирдамжийн дагуу зохион байгуулж, тайланг Олон улсын цус сэлбэлтийн нийгэмлэгт 2025 оны 11 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Л.Энхчимэг)-д үүрэг болгосугай.

4. Шаардагдах төсвийг Олон улсын цус сэлбэлтийн нийгэмлэгийн санхүүжилтээс зориулалтын дагуу гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч (Х.Одгэрэл)-д зөвшөөрсүгэй.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цусны чанар аюулгүй байдлын албаны дарга (Э.Тунгалагтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

ЦССҮТ-ийн захирлын 2025 оны
09 дүгээр сарын 11-ний өдрийн
156 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Энхчимэг	Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга
Нарийн бичиг:	Ж.Нармандах	Сувилахуй үйлчилгээний албаны дарга
Гишүүд:	Э.Тунгалагтуяа	Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга
	М.Цэрэндэжид	Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч
	Б.Ижилбаатар	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч
	Б.Додьгалсан	Инженер техникийн тасгийн эрхлэгч
	Б. Оргил	Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч
	Б.Өнөрцэцэг	Үйлдвэрлэлийн тасгийн ахлах сувилагч
	Д.Оюунболд	Нэгдсэн лабораторийн тасгийн ахлах лаборант
	Д.Одмаа	Донор зохион байгуулалтын тасгийн ахлах сувилагч

ЦССҮТ-ийн захирлын 2025 оны
09 дүгээр сарын 11-ний өдрийн
А/36 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

1118266548 ᠎.9128905

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН СУВИЛАГЧДЫН II ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Үндэслэл:

Цус сэлбэлт судлалын салбар нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний салшгүй нэг хэсэг бөгөөд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас цусны чанар, аюулгүй байдлыг хангах цогц стратегийг хэрэгжүүлэхийг онцлон зөвлөж байна. Энэхүү стратегийн хүрээнд эмч, мэргэжилтнүүд цусны аюулгүй байдлын талаарх мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, харилцан туршлага солилцож цаашдын зорилго зорилтоо хамтран тодорхойлох нь салбарын хөгжилд чухал ач холбогдолтой байна.

Зорилго:

Цусны аюулгүй байдал, хүртээмжийг сайжруулахад сувилагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох замаар оролцоог бэхжүүлэхэд оршино.

Зорилт:

- Цусны чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд сувилагчдын оролцоог нэмэгдүүлэх
- Салбарын мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэг олгох
- Хууль эрх зүйн хэрэглээний чадварыг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэгч байгууллага:

- Цус сэлбэлт судлалын үндэсний төв

Оролцогч талууд:

- Цусны салбар төвүүд
- Монголын сувилагчийн нийгэмлэг
- Сувилахуйн сургуулиуд

Хугацаа:

2025 оны 09 дүгээр сарын 25–26

Санхүүжүүлэгч байгууллага:


Олон Улсын Цус Сэлбэлтийн Нийгэмлэг (ISBT)

Хүлээгдэж буй үр дүн:

- Цус, цусан бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангахад сувилагч, тусгай мэргэжилтний оролцоо сайжирна.
- Салбарын сувилагч, тусгай мэргэжилтнийг мэдээлэл технологийн чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангасан байна.
- Салбарын сувилагч, тусгай мэргэжилтний хууль эрх зүй ашиглах, хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангасан байна.

---oOo---

ЦССҮТ-ийн захирлын 2025 оны
09 дүгээр сарын 11-ны
өдрийн 11/26 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт



ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ (MNT)	Нийт зардал (MNT)
1.	Оролцогчдын тээврийн зардал	30	531250	15937500
2.	Оролцогчдын хоолны зардал	120	68000	8160000
3.	Кофе завсарлага	120	12750	1530000
4.	Хурлын өрөө	8	170000	1360000
5.	Орчуулгын хөлс (имэйл, баримт бичигийн орчуулга, ISBT-ийн тайлан)	15	63750	956250
6.	Вэб хуудас Платформын захиалга	1	85000	85000
7.	Мэдээллийн технологийн ажлын зардал	2	127500	255000
8.	Илтгэл, гардан үйлдлийн хичээлийн бэлтгэл, бичлэг	2	127500	255000
9.	Лабораторийн урвалж болон гардан үйлдлийн хэрэглэгдэхүүнүүдийн зардал	60	25500	1530000
НИЙТ				30068750

Цус сэлбэлт судлалын үндэсний
төвийн захирлын 2025 оны
09 дүгээр сарын 17-ны
өдрийн А/56 дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН СУВИЛАГЧДЫН II ЗӨВЛӨГӨӨН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
1.	Сургалтын удирдамж боловсруулж батлуулах	2025.08.20	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах	Захирал Б.Нарантуяа
2.	Албан бичиг төлөвлөж сургалтын удирдамж хүргүүлэх	2025.09.10	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг	Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Нинжбадгар
3.	Сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулах	2025.09.11	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах	Захирал Б.Нарантуяа
4.	ДЭМБ-ийн "Цусны аюулгүй байдлын стратеги" орчуулах	2025.09.15	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг	ЦССҮТ-ийн Зөвлөх Т.Алимаа
5.	Зочин лекц унших багш олох	2025.09.15	Захирал Б.Нарантуяа	
6.	Сургалтын өмнөх асуумж боловсруулах /өөр өөрийн сэдвийн хүрээнд/	2025.09.20	Албаны дарга, тасгийн эрхлэгч нар	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах
7.	Зочид хүлээн авах бүртгэх	2025.09.25	ДЗБТ-ийн ахлах Д.Одмаа ҮТ-ийн ахлах Б.Өнөрцэцэг НЛТ-ийн ахлах Д.Оюунболд	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах

8.	Нээлтийн үг бэлтгэх, зочидын нэрс гаргах	2025.09.23	СҮА-ны дарга Ж.Нармандах	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг
9.	Дурсгалын болон сургалтын нээлтийн зураг авах тараах	2025.09.25	ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах
10.	Сургалтын заал бэлтгэх, орчин бүрдүүлэх /цэвэрлэгээ, сандал ширээ засах, хөгжим, техник хэрэгсэл, компьютер/	2025.09.24	ДЗБТ-ийн ахлах Д.Одмаа ҮТ-ийн ахлах Б.Өнөрцэцэг ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн	СҮА-ны дарга Ж.Нармандах
11.	Бичиг хэргийн төсөв гаргах, зохион байгуулах	2025.09.15	ДЗБТ-ийн ахлах Д.Одмаа ҮТ-ийн ахлах Б.Өнөрцэцэг НЛТ-ийн ахлах Д.Оюунболд	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах
12.	Вэб сайт нээх бүртгэл үүсгэх	2025.09.20	IT, ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг
13.	Баннар, постер, урилгын загвар гаргах, илгээх	2025.09.20	IT, ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг
14.	PPT загвар гаргах	2025.09.12	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах	ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн
15.	Стратегийн лекц, багийн ажлын асуумж, зөвлөмж бэлтгэх	2025.09.23	ЦССҮТ-ийн Зөвлөх Т.Алимаа	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах
16.	1-6 зорилтын лекц, дадлага ажил, асуумж, зөвлөмж бэлтгэх	2025.09.23	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг	
17.	2-3-р зорилтын лекц, дадлага ажил, асуумж, зөвлөмж бэлтгэх	2025.09.23	ДЗБТ-ийн эрхлэгч технологич их эмч Б.Ижилбаатар ҮТ-ийн эрхлэгч Б.Оргил НЛТ-ийн эрхлэгч М.Цэрэндэжид	

18.	4-р зорилтын лекц, дадлага ажил, асуумж, зөвлөмж бэлтгэх	2025.09.23	ЦЧАБА-ны дарга Э.Тунгалагтуяа	
19.	5-р зорилтын лекц, дадлага ажил, асуумж, зөвлөмж бэлтгэх	2025.09.23	ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн	
20.	Өдрийн хоол, цай кофе төсөв гаргаж, гэрээ хийх газар олох, гэрээ байгуулж хэрэгжүүлэх	2025.09.20	СҮА-ны дарга Ж.Нармандах	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг
21	Тойролт тус бүрд хийгдэх үйл ажиллагааны жагсаалт гаргах хэрэгжүүлэх	2025.09.23	ДЗБТ-ийн ахлах Д.Одмаа ДЗБТ-ийн сувилагч Э.Дашгарав ҮТ-ийн ахлах Б.Өнөрцэцэг НЛТ-ийн ахлах Д.Оюунболд	ДЗБТ-ийн эрхлэгч технологич их эмч Б.Ижилбаатар ҮТ-ийн эрхлэгч Б.Оргил НЛТ-ийн эрхлэгч М.Цэрэндэжид ЭШМТА-ны инженер Ч.Далайцэрэн
22	Багц цагийн сургалтын хөтөлбөр батлуулж, зарлах	2025.09.20	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг	Захирал Б.Нарантуяа
23	Сургалтаас гарах зөвлөмжийн төсөл боловсруулах	2025.09.20	ЦССҮТ-ийн Зөвлөх Т.Алимаа	Албаны дарга, тасгийн эрхлэгч нар
24	Орж ирсэн төсвийг зориулалтын дагуу хугацаанд нь хуулийн дагуу шилжүүлэх	2025.09.15-10.20	СБА-ны дарга ахлах нягтлан бодогч Х.Одгэрэл	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг СҮА-ны дарга Ж.Нармандах
25	Тайлан бичиж, орчуулсан хувийг ISBT хүргүүлэх	2025.11.01	СҮА-ны дарга Ж.Нармандах	ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг

Төлөвлөгөө боловсруулсан: ЭШМТА-ны дарга Л.Энхчимэг
СҮА-ны дарга Ж.Нармандах